



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 24

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас
балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 126,000 (нэг зуун хорин зургаан мянга) төгрөгийн балансын үнэтэй, 68,250 жаран найман мянга хоёр зуун тав) төгрөгийн үлдэх өртөгтэй LCMS224-39207 маркийн телевизорыг Луус сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөд балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ш.Энхсүх), Луус сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Н.Долгоржав) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Шилжүүлэх хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хүлээлцэн, холбогдох хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.2. Энэ тогтоолын биелэлтийг 2024 оны 5 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.


3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 04 дүгээр сарын 22-ний өдрийн
24 тогтоолын хавсралт



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	LCMS224-39207 телевизор	2021.12.31	ш	1	126,000	57,750	68,250	Луус сумын Ерөнхий боловсролын сургууль
Нийт дүн					126,000 (нэг зуун хорин зургаан мянга) төгрөг	57,750 (тавин долоон мянга долоон зуун тавь) төгрөг	68,250 (жаран найман мянга хоёр зуун тавь) төгрөг	